



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/210.

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
шинээр олгох, тусгай зөвшөөрөлд
чиглэл нэмэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 3.2 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.4, 19.3.8, 19.5.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яам төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн даргын зөвлөлийн хуралд танилцуулсны дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 6 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх 2 хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхийг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг хуулийн этгээдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-д, тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-д тус тус даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТЦООЖ




Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 11 дугаар сарын 04-ны өдрийн
11/310 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл	Хаяг
1.	Эппле нинж групп ХХК /7194921/	Клиник	Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /Оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний согог, гажиг засал/	Баянгол дүүргийн 11-р хороо 4-р хороолол Энэбишийн өргөн чөлөөний гудамж 1/26 1 давхар
2.	Уранус мэн ХХК /7180689/	Клиник	Урологи, Лабораторийн тусламж, үйлчилгээ /клиник хими, биохими, иммунологи/	Баянгол дүүрэг, 16-р хороо, Амарсанаа гудамж, Орхон 66
3.	Дентал тэмүүлэл студио ХХК /7165833/	Клиник	Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /Оношилгоо, эмчилгээ, шүдний өвчний гажиг засал/	БЗД, 4-р хороо, Энхтайвны өргөн чөлөө Жоби72-37р байрны 1-р давхарын хэсэг
4.	Баясах мед жигүүр ХХК /8433062/	Клиник	Дотор, Хүүхэд, Мэдрэл, Гэмтлийн өвчний тусламж, үйлчилгээ, Дүрс оношилгоо, Сэргээн засах	БЗД, 39-р хороо, Улаанхуаран, 13302, Цагдаагийн академийн өргөн чөлөө гудамж, 34/6 тоот
5.	Мэргэн номт анам ХХК /7002121/	Эмийн сан	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Хан-Уул дүүрэг, Яармаг Наадамчдын зам гудамж 926-р байр 1 давхар 101 тоот
6.	Нарны чулуу трейд ХХК /6018076/	Эмийн сан	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Хан-Уул дүүрэг, 4-р хороо, ханбогд хотхон наадамчдын зам гудамж, 205 байр, 2 тоот

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 11 дугаар сарын 09-ны өдрийн
А/310 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ЧИГЛЭЛ НЭМЭХ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ



д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөлд нэмэх чиглэл
1.	Энхсаран ХХК /2646196/	Клиник	Шүдний өвчний тусламж, үйлчилгээ /оношилгоо, эмчилгээ/, Сэтгэцийн өвчний тусламж, үйлчилгээ
2.	Содтопаз ХХК /5127041/	Клиник	Лабораторийн тусламж, үйлчилгээ